



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/154/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	14
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Албан шаардлага	15
4.1 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

add. ol. 25 № *2/41*

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА Г

танай _____ -ны № _____ -г

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

005020297

D:\Alban bichig\A4-toot.docx

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41,447,929.38</u>	<u>48,292,929.38</u>
33	АВЛАГА	57,465.38	5,629,335.38
335	Бусад авлага	57,465.38	5,629,335.38
3351	Байгууллагаас авах авлага	57,465.38	5,629,335.38
35	БАРАА МАТЕРИАЛ	41,390,464.00	42,663,594.00
354	Хангамжийн материал	41,390,464.00	42,663,594.00
35410	Бичиг хэргийн материал	402,239.00	553,809.00
35420	Аж ахуйн материал	10,667,425.00	12,109,785.00
35440	Түлш, шатах тослох материал	320,800.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	30,000,000.00	30,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,589,870,046.72</u>	<u>11,063,388,469.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,589,870,046.72	11,063,388,469.95
392	Биет хөрөнгө	9,589,870,046.72	11,063,388,469.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,126,427,951.21	13,466,997,466.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,670,026,401.04)	(2,506,805,463.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	803,612,390.06	772,812,390.06
39204	Хуримтлагдсан элэгдэл	(743,412,390.14)	(745,229,056.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,131,400.00	45,287,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,967,085.95)	(25,681,623.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,807,770.00	20,271,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,622,810.01)	(11,251,505.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,321,341.50	61,321,341.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,720,418.91)	(14,651,798.09)
39217	Ном	318,300.00	318,300.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,631,317,976.10</u>	<u>11,111,681,399.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,818,223,385.83</u>	<u>4,818,223,385.83</u>
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,818,223,385.83	4,818,223,385.83
422	Урт хугацаат зээл	4,818,223,385.83	4,818,223,385.83
4221	Төгрөг	4,818,223,385.83	4,818,223,385.83
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,818,223,385.83	4,818,223,385.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,813,094,590.27</u>	<u>6,293,458,013.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,813,094,590.27	6,293,458,013.50
512	Хуримтлагдсан үр дүн	(286,829,500.21)	1,193,533,923.02
51210	Өмнөх үеийн үр дүн	(286,829,500.21)	(286,829,500.21)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,480,363,423.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,099,924,090.48	5,099,924,090.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,631,317,976.10</u>	<u>11,111,681,399.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	306,524,924.50	2,604,006,935.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,479,824.50	2,418,199,565.00
120	Нийтлэг татварын бус орлого	128,479,824.50	2,418,199,565.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,479,824.50	2,417,704,865.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,953,401.00	65,500,550.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	0.00	2,352,204,315.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	0.00	494,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	178,045,100.00	185,807,370.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	5,571,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	5,571,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,045,100.00	180,235,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,045,100.00	180,235,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,227,840,564.16	1,098,858,417.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,227,840,564.16	1,098,858,417.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,666,434.20	1,037,425,011.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	128,741,017.07	141,244,798.00
210101	Үндсэн цалин	100,615,679.53	94,341,436.00
210102	Нэмэгдэл	21,342,337.54	33,483,362.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,783,000.00	13,420,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,642,079.09	18,292,682.70
210201	Тэтгэврийн даатгал	11,920,885.41	13,160,259.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,239,657.08	1,267,290.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,003,725.66	1,129,957.69
210204	Ажилгүйдлийн даатгал	228,866.24	267,877.60
210205	Эрүүл мэндийн даатгал	2,248,944.70	2,467,297.96
2104	Хангамж, бараа материалын зардал	12,799,094.89	9,298,229.32
210401	Бичиг хэрэг	4,521,140.00	3,285,330.00
210402	Тээвэр, шатахуун	5,581,000.00	4,662,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,366,454.89	1,199,999.32
210404	Ном, хэвлэл	322,000.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,008,500.00	-
2105	Нормативт зардал	3,500,000.00	2,000,000.00
210502	Хоол, хүнс	3,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,838,500.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,838,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,613,405.00	5,947,004.00

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,089,900.00	5,619,940.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	121,005.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,500.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	11,000.00	27,064.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	978,370,838.15	855,803,797.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	976,030,838.15	855,803,797.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,174,129.96	61,433,405.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,433,836.00	2,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,433,836.00	2,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,593,401.00	58,500,550.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,593,401.00	58,500,550.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,146,892.96	782,855.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,146,892.96	782,855.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(921,315,639.66)</u>	<u>1,505,148,517.61</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,030,800.00	24,785,094.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,030,800.00)	(24,785,094.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(929,346,439.66)</u>	<u>1,480,363,423.23</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>256,998,501.00</u>	<u>251,307,920.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,953,401.00	65,500,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	78,953,401.00	65,500,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,953,401.00	65,500,550.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,953,401.00	65,500,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	178,045,100.00	185,807,370.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	5,571,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,571,870.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,045,100.00	180,235,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,045,100.00	180,235,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>251,458,501.00</u>	<u>251,307,920.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,458,501.00	251,307,920.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	183,284,371.04	184,302,644.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	128,818,979.96	141,244,798.00
210101	Үндсэн цалин	94,918,442.42	94,341,436.00
210102	Нэмэгдэл	25,665,537.54	33,483,362.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,235,000.00	13,420,000.00

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,544,791.19	18,292,682.70
210201	Тэтгэврийн даатгал	11,422,698.52	12,791,028.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,313,479.03	1,425,047.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,033,983.16	1,129,957.69
210204	Ажилгүйдлийн даатгал	252,239.40	267,877.60
210205	Эрүүл мэндийн даатгал	2,522,391.08	2,678,770.58
2104	Хангамж, бараа материалын зардал	12,350,194.89	9,892,099.32
210401	Бичиг хэрэг	4,674,500.00	4,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,901,800.00	4,342,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,433,894.89	1,199,999.32
210404	Ном, хэвлэл	340,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	3,500,000.00	2,000,000.00
210502	Хоол, хүнс	3,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,000,000.00
210602	Тавилга	00.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,838,500.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,838,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,730,405.00	6,034,564.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,206,900.00	5,707,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	121,005.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,500.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	27,064.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,340,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,174,129.96	67,005,275.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,433,836.00	2,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,433,836.00	2,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,593,401.00	58,500,550.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,593,401.00	58,500,550.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,146,892.96	782,855.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,146,892.96	782,855.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,571,870.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	5,571,870.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,540,000.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,540,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,540,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,540,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,540,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,540,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	6,330,294,631.64	00.00	11,430,218,722.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	6,330,294,631.64	00.00	11,430,218,722.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-218,314,152.12	00.00	-218,314,152.12
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	-286,829,500.21	00.00	4,813,094,590.27
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	-286,829,500.21	00.00	4,813,094,590.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	-286,829,500.21	00.00	4,813,094,590.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,480,363,423.23	00.00	1,480,363,423.23
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	1,193,533,923.02	00.00	6,293,458,013.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	187,235,500.00	186,452,644.02	782,855.98	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,235,500.00	186,452,644.02	782,855.98	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,085,500.00	184,302,644.02	782,855.98	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,244,800.00	141,244,798.00	2.00	100.0
210101	Үндсэн цалин	99,283,200.00	94,341,436.00	4,941,764.00	95.0

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	26,121,600.00	33,483,362.00	(7,361,762.00)	128.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,840,000.00	13,420,000.00	2,420,000.00	84.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,068,100.00	18,292,682.70	775,417.30	95.9
210201	Тэтгэврийн даатгал	13,418,300.00	12,791,028.85	627,271.15	95.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,412,400.00	1,425,047.98	-12,647.98	100.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,130,000.00	1,129,957.69	42.31	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	282,500.00	267,877.60	14,622.40	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	2,824,900.00	2,678,770.58	146,129.42	94.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,892,100.00	9,892,099.32	0.68	100.0
210401	Бичиг хэрэг	4,200,000.00	4,200,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,342,100.00	4,342,100.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,199,999.32	0.68	100.0
210404	Ном, хэвлэл	150,000.00	150,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,843,000.00	2,838,500.00	4,500.00	99.8
210702	Дотоод албан томилолт	2,843,000.00	2,838,500.00	4,500.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,037,500.00	6,034,564.00	2,936.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,707,500.00	5,707,500.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	27,064.00	2,936.00	90.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2150000.00	2150000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,150,000.00	2,150,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,150,000.00	2,150,000.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг дарга Ц.Идэрмөнх, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Дуламсүрэн нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилго. Орон нутгийн төсөвт байгууллагууд болон Төрийн өмчийн оролцоотой ОНӨҮГ-ын өмч, хөрөнгийн харилцааг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн хүрээнд зохицуулах. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж, бүх шатны төсвийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, ил тод байдал, харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж, авлигал гарах нөхцөлийг бууруулах, дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийг дэмжих, шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хурдасгахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Чиг үүрэг. Орон нутгийн өмчийн хөрөнгийг хамгаалах, шилжүүлэх, актлах гэх мэт харилцааг зохицуулах мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45.5-д болон 48.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн захиалгыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бараа ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагааг энэхүү хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,227,840.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,278.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,594.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангаар материаллаг байдлыг авсан бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 7692.0 мянган төгрөг буюу төлөвлөлтийн үе шатнаас 1289.8 мянган төгрөгөөр буурч байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,480,363.4 мянган төгрөгөөр буюу 15.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,447.9	48,292.9	6,845.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	57.5	5,629.3	5,571.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	41,390.5	42,663.6	1,273.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,589,870.0	11,063,388.5	1,473,518.4
Үндсэн хөрөнгө	12,051,069.2	14,367,457.9	2,316,388.8
Хуримтлагдсан элэгдэл	(2,461,199.1)	(3,304,069.4)	(842,870.3)
Нийт хөрөнгө	9,631,318.0	11,111,681.4	1,480,363.4
Өр төлбөр	4,818,223.4	4,818,223.4	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,813,094.6	6,293,458.0	1,480,363.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,631,318.0	11,111,681.4	1,480,363.4

Өмнөх онд авлагын данс 57.5 мянган төгрөг байсан бол тайлант онд 5,629.3 мянган төгрөг болж 5,571.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд авлага өссөн шалтгаан нь оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансанд 5,571.9 мянган төгрөгийн давсан орлого хуваарилагдаж буцаан татагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,663.6 мянган төгрөг болж 1,273.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 1,442.4 мянга, бичиг хэргийн материал 151.6 мянга, төгрөгөөр өсөж, түлш шатах тослох материал 320.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,367,467.9 мянган төгрөг болж 2,316,388.8 мянган төгрөгөөр өссөн нь 2,324,428.1 мянган төгрөгийн 2,4,5,7 дугаар багуудын шугам сүлжээ, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 52 тоот тогтоолоор 16,141.4 мянган төгрөгийн 6 дугаар багийн гүний худгийг орон нутгийн өмчид бүртгэсэн, Тайлант онд аймгийн ИТХ-ын 2021 оны 52 тоот тогтоолоор 2,708.5 мянган төгрөгийн хөрөнгийг Өлзийт сумын ЭМТ-д шилжүүлсэн, 28 дугаар тогтоолоор 30,800.0 мянган төгрөгийн автомашиныг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн, 116 дугаар тогтоолоор 4,107.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Тайлант онд 4,818,223.4 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийг бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,293,458.0 мянган төгрөг болж 1,480,363.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 244,218.8 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 237,218.8 мянга, үйл ажиллагааны орлогоос 7,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 56,983.3 мянган төгрөгөөр бууруулж 187,235.5 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Төсөвлөсөн зардлаас цалингийн зардлыг 719.1 мянга, хангамж материалын зардлыг 13,820.5 мянга, нормативд зардлыг 3,000.0 мянга, томилолтын зардлыг 7,307.5 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 20,235.0 мянга, БГАҮ-ний зардлыг 12,054.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 187,235.5 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 180,235.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, өөрийн орлогоор 7,000.0 мянган төгрөгөөр төгрөг оруулахаар-баталсан байна .

Гүйцэтгэлээр төсвөөс 180,235.5 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогоор 65,500.6 мянган төгрөгийг төвлөрүүлэн 58,500.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогод шилжүүлж, 7,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор авч, 186,452.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 782.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 186,452.6 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа бөгөөд тайлант онд ЭМНДШ-ийн зардлыг 775.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар оны эцэст 5,551.9 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 98.6%-тай дүгнүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,098,858.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 128,982.2 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь элэгдлийн зардал буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 256,337.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 101,411.8 мянган төгрөгийн 134 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 154,925.6 мянган төгрөгийн 15 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв. Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	2	2	0
3	Улирал бүр	1	4	3	1	0
4	Сар бүр	3	36	33	3	0
5	Тухай бүр	8	96	88	8	0
6	Нийт	27	151	134	15	2

3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 187,235.5 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 186,452.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,111.9 мянган төгрөг буюу 0.4 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 2,843.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,838.5 мянган төгрөг зарцуулж 4.5 мянган төгрөг хэмнэжээ.

- Тухайн байгууллага нь аймгийн ЗДТГ-ын байранд барлаж байгаа тул байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсөв батлагдаагүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөвтэй холбоотой 116 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,973.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг сумын ЗДТГ-ын даргын 2021.05.11-ний өдөр төлбөрийн актыг орон нутгийн төсөвт буцаан төлсөн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг 2021.08.16-ны а/174 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156,725.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 1,800.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 154,925.6 мянган төгрөгийн 1 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.1 Албан шаардлага

1.1. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2021.02.24-нд 1800.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 256,337.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 101,411.8 мянган төгрөгийн 134 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 154,925.6 мянган төгрөгийн 15 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	2	156,725.6	0	0	0	0	1	1,800.0	1	0

_____оОо_____